



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

### Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн, нийт 117,000,000.00 (нэг зуун арван долоон сая) төгрөгийн балансын үнэ, 42,000,000.00 (дөчин хоёр сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дарханы дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Батжаргал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2023 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132205059  
12-rnuraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 05 дугаар сарын .....-ны өдрийн  
..... дугаар тогтоолын хавсралт

"Дарханы дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 424 дүгээр тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Волво ачааны машин, улсын дугаар 02-05 ДАА, 02-05 АЧ чиргүүлийн хамт, арлын дугаар YV2AS02A38B516654, WSMS6980000474432	2008/2018	75,000,000.00	0.00	75,000,000.00	75,000,000.00	65,000,000.00
2	Цевролет каптива /Chevrolet captiva/, улсын дугаар 07-09 ДАХ, арлын дугаар KL1CD26UECB059360	2012/2012	42,000,000.00	42,000,000.00	0.00	8,000,000.00	5,000,000.00
Нийт дүн			117,000,000.00	42,000,000.00	75,000,000.00	83,000,000.00	70,000,000.00
			(нэг зуун арван долоон сая)	(дөчин хоёр сая)	(далан таван сая)	(наян гурван сая)	(далан сая)